

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**



ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
ЭРХЛЭХ ХҮРЭЭНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭНИЙ 2026 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ЯВЦЫН АУДИТ**

Аудитын код: ДА-2026/21-ТБ

Сэлэнгэ аймаг
2026

АГУУЛГА

№	Бүлэг, дэд бүлгийн нэр	Хуудас
1	Товчилсон үгийн жагсаалт	2
2	Хүснэгтийн товъёг	2
3	Нийтлэг үндэслэл	3
4	Ерөнхий мэдээлэл	4
5	Аудитаар илрүүлсэн асуудал	5
6	Дүгнэлт	9
7	хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж	11
8	Цаашид анхаарах асуудал	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ХБОСС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
БОУАӨ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт
ТБОНХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХАА	Хөдөө аж ахуй

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Хүснэгтийн нэр	Хуудас
Хүснэгт 1	Аудитад хамрагдсан 8 төсөл, арга хэмжээний жагсаалт	4
Хүснэгт 2	Тендер зарлах хугацааны хэрэгжилт	5
Хүснэгт 3	Гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний нэгдсэн мэдээлэл	8

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын баталсан 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ДА-2026/21-ТБ дугаартай аудитын удирдамж, Сангийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01/3386 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийг үндэслэн Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд явцын дотоод аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитыг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитын багийн ахлагчаар Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Мөнхзул, бүрэлдэхүүнд дотоод аудитор Г.Дорждэрэм, Д.Ванчигмаа нар оролцов.

1.1. Аудитын зорилго

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийн явцад дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

1.2. Аудитын хамрах хүрээ

Тус аудитад Сэлэнгэ аймагт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (УТХО) эрх шилжиж ирсэн дараах нийт 8 төсөл, арга хэмжээг хамруулсан:

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2026 онд нийт 312,888,400.0 мянган төгрөгийн 21 төсөл арга хэмжээ батлагдсанаас аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж ирсэн (Спорт заалны барилга /Жавхлант сум/, Сургуулийн спорт заалны барилга /Сайхан сум, Номгон тосгон/, Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Түшиг сум/); **3 төсөл, арга хэмжээ** байна.

Харин 2024 оноос хойш он дамжин хэрэгжиж буй (Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 6.3 км /Сүхбаатар сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам 10.3 км /Мандал сум/, Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил, Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк). **4 төсөл, арга хэмжээ** байна.

Загас үржүүлгийн төв байгуулах төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах газарт зохион байгуулж, гэрээ байгуулах, ашиглалтад хүлээлгэн өгөх, өмчид бүртгэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах эрхийг МУХББОСС-ын 2026 оны 25 дугаар тушаалаар шилжүүлсэн байна.

Дээрх 8 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 41,167,600.0 мянган төгрөг бөгөөд бүгдийг "Худалдан авах ажиллагааны дотоод аудитын шалгах хуудас"-аар тус бүрчлэн шалгасан болно.

1.3. Аудитын арга зүй

Аудитыг дотоод аудитын дэлхийн стандартууд болон Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын явцад баримт бичгийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт, ажиглалт, ярилцлага зэрэг арга зүйг ашиглан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)-д бүртгэгдсэн мэдээлэлтэй тулган баримтжуулсан болно.

ХОЁР. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар Сэлэнгэ аймагт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ) болон 11 яаманд харьяалагдах нийт 322,823.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 21 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс аймгийн Засаг даргад нийт 41,167.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

Эрх шилжсэн 8 төсөл, арга хэмжээний дотор 2026 онд шинээр санхүүжих 3 төсөл, мөн өмнөх жилээс он дамжин хэрэгжиж байгаа 5 төсөл байгаа ба эдгээрийг "Монгол Улсын 2021-2025, 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Хүний хөгжил, Эдийн засаг, Засаглал, Амар тайван, аюулгүй нийгэм гэсэн үндсэн 4 зорилготой нийцүүлэн төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Аудитад хамрагдсан 8 төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжсэн үндэслэл	Төсөвт өртөг (сая ₮)	Хэрэгжих хугацаа
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Сэлэнгэ, Түшиг сум/	ЗГХЭГ-ын даргын 2026 оны 01 тушаалын 2 дугаар хавсралт	7,036.7	Он дамжин
2	Сургуулийн спорт заалны барилга /Сэлэнгэ, Сайхан сум, Номгон тосгон/ - дуусгал	Боловсролын сайдын 2026 оны А/02 тушаалын 4 дүгээр хавсралт	2,072.8	Он дамжин
3	Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил	ХБОСС-ын 2025 оны 25 тушаалын 1 дүгээр хавсралт	4,040.2	2025-2027
4	Загас үржүүлгийн төв /Сэлэнгэ/	БОУАӨ сайдын 2026 оны А/306 тушаал	1,173.8	2026
5	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 6.3 км /Сүхбаатар сум/	ЗГ-ын 2023 оны 409 тогтоолын 2 дугаар хавсралт	9,444.4	2024-2026
6	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 10.3 км /Мандал сум/	ЗГ-ын 2023 оны 409 тогтоолын 2 дугаар хавсралт	10,004.7	2024-2026

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжсэн үндэслэл	Төсөвт өртөг (сая ₮)	Хэрэгжих хугацаа
7	Спорт заалны барилга /Сэлэнгэ, Жавхлант сум/	ЗГ-ын 2023 оны 409 тогтоолын 2 дугаар хавсралт	2,455.5	2024-2027
8	Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/	ЗГ-ын 2023 оны 409 тогтоолын 2 дугаар хавсралт	4,939.5	2024-2025
	НИЙТ	8 төсөл, арга хэмжээ	41,167.6	

ГУРАВ. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ

Аудитын шалгах хуудсаар 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 20 шалгуур үзүүлэлтээр тус бүрчлэн шалгасан бөгөөд илрүүлсэн зөрчил, дутагдлуудыг дараах байдлаар нэгтгэв.

3.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

Аудитад хамрагдсан 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө бүгд батлагдан цахим систем (tender.gov.mn)-д хууль зүйн хугацаанд нийтлэгдсэн байна. Гэвч төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалт зарласан байдлыг шалгахад дараах зөрчил илэрсэн:

Хүснэгт 2. Тендер зарлах хугацааны хэрэгжилт

№	Төсөл, арга хэмжээ	Төлөвлөсөн огноо	Бодит зарласан огноо	Үнэлгээ
1	Загас үржүүлгийн төв /Сэлэнгэ/	2026.01.20	2026.03.19	Хугацаа хоцорсон
2	Сургуулийн спорт заалны барилга /Сайхан сум, Номгон тосгон/	2026.03.25	2026.04.06	Хугацаа хоцорсон
3	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төв /Түшиг сум/	2023.12.28	3 удаа зарласан: 2024.03.22, 2024.05.08, 2026.06.25	Хугацаа хоцорсон, давтан зарласан
4	Аймгийн төвийн авто зам 6.3 км /Сүхбаатар сум/	2023.12.28	2 удаа зарласан: 2024.03.22, 2024.05.08	Хугацаа хоцорсон, давтан зарласан
5	Сумын төвийн авто зам 10.3 км /Мандал сум/	2023.12.28	2024.03.20	Хугацаа хоцорсон
6	Спорт заалны барилга /Жавхлант сум/	2026.02.01	2026.03.20	Хугацаа хоцорсон
7	Дулааны станцын	2025.02.03	2025.02.06	Хугацаа

№	Төсөл, арга хэмжээ	Төлөвлөсөн огноо	Бодит зарласан огноо	Үнэлгээ
	хамааралгүй схем			хоцорсон
8	ХАА-н үйлдвэржилтийн агропарк	2024.01.31	2 удаа зарласан: 2024.05.05, 2024.09.16	Хугацаа хоцорсон, давтан зарласан

Дүгнэлт: Аудитад хамрагдсан **8 төсөл, арга хэмжээний 100 хувь буюу бүгдэд** нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалтыг зарлаагүй, түүний дотор 3 төсөл арга хэмжээний хувьд (Иргэдэд үйлчлэх мэдээллийн төв, Аймгийн төвийн авто зам, ХАА-н агропарк) тендерийг 2-3 удаа давтан зарласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн (ТБОНХБАҮХАТХ) 44.4 дүгээр зүйлд заасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд нь баталгаажуулж хэрэгжүүлэх шаардлагыг хангаагүй болохыг харуулж байна.

3.2. Зураг төсөл, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийн бүрдэл

Аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээнүүдийн зураг төсөл, техникийн нөхцөл, газрын зөвшөөрөл, ажил эхлүүлэх зөвшөөрөл болон магадлалын дүгнэлтийн бүрдлийг шалгахад дараах ноцтой зөрчил, дутагдал илэрсэн:

3.2.1. Загас үржүүлгийн төв /Сэлэнгэ/ — 1,173.8 сая ₮

Тус төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт баталгаажуулагдаагүй, газрын зөвшөөрөлгүй, цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга, холбоо дохиоллын техникийн нөхцөлүүд авагдаагүй, ажил эхлүүлэх зөвшөөрөлгүй байна. Магадлалын ерөнхий дүгнэлтгүйгээр батлагдсан иж бүрэн зураг төсөл, мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийгдсэн өртгийн төсөвгүйгээр худалдан авах ажиллагааг зарласан нь Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төслийн иж бүрдлийн шаардлагыг хангаагүй байна. Дээрх нөхцөлд төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил хангагдаагүй атал 1,173.8 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөгдөж, тендерийг 2026.03.19-нд зарласан нь Барилгын тухай хуулийн 4.1.8, 23.2 дугаар зүйлд заасан техникийн нөхцөлийн шаардлагыг хангаагүй болохыг харуулж байна.

3.2.2. Сургуулийн спорт заалны барилга /Сайхан сум, Номгон тосгон/ — 2,072.8 сая ₮

Тус төсөл арга хэмжээний төсөвт өртөг 1,482.1 сая төгрөг байсан бөгөөд 2026 онд 2,072.8 сая төгрөг болж 590.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. 2025 онд төсөл хэрэгжүүлэх ажиллагаа эхэлсэн боловч газрын зөвшөөрөл олгогдоогүй, цахилгаан, дулаан, ус хангамжийн техникийн нөхцөлүүд авагдаагүй, ажил эхлүүлэх зөвшөөрөлгүй байна. Магадлалын дүгнэлтээр зураг, төсвийг баталгаажуулаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 4.1.8 болон 23.2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн нөхцөл бүрдээгүй нөхцөлд санхүүжилт төлөвлөгдсөн эрсдэлтэй байна.

3.2.3. Аймгийн төвийн авто зам, 6.3 км /Сүхбаатар сум/ — 9,444.4 сая ₮

Зураг төсөл нь 2023 оны 06 дүгээр сарын 26-ний өдөр боловсруулагдаж, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр авсан бөгөөд магадлалын ерөнхий дүгнэлт гарсан байна. Гэвч цахилгаан, дулаан, ус хангамж, холбооны техникийн нөхцөлүүдийг аваагүй байхад ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон нь төслийн бэлтгэл ажлын уялдаа, хуульд нийцсэн дараалал алдагдсан эрсдэлтэй байна.

3.2.4. Сумын төвийн авто зам, 10.3 км /Мандал сум/ — 10,004.7 сая ₮

Зураг төсөл боловсруулагдсан, ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2024.06.14-нд авсан, магадлалын ерөнхий дүгнэлт гарсан хэдий ч цахилгаан, дулаан, ус хангамж, холбооны техникийн нөхцөлүүд бүрэн авагдаагүй, газрын асуудал шийдвэрлэгдээгүй нөхцөлд төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь хэрэгжилтийн явцад хугацаа алдах, нэмэлт зардал үүсэх эрсдэлийг бий болгож байна.

3.2.5. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Түшиг сум/ — 7,036.7 сая ₮

Анхны төсөвт өртөг 2,453.9 сая төгрөг байсан тус арга хэмжээг 2026 онд 7,036.7 сая төгрөг болгож 4,582.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Зураг төсөл 2023.10.02-нд батлагдсан, төсөв нэмэгдсэнээс хойш шинэчилж батлуулаагүй, газрын зөвшөөрлийг 2012.04.24-нд олгосон бөгөөд цахилгаан, дулааны техникийн нөхцөлүүдийг 2021.09.22, 2024.04.30-нд авсан хэдий ч ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл авагдаагүй байна. Батлагдсан иж бүрэн зураг төсөл, мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийгдсэн өртгийн төсөвгүйгээр худалдан авах ажиллагааг зарласан нь Барилгын тухай хуулийн 24.2 болон 4.1.30 дугаар зүйлд заасан зураг төсөл, төсвийн бүрдлийг хангаагүй, хуульд нийцээгүй нөхцөлөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

3.2.6. Спорт заалны барилга /Жавхлант сум/ — 2,455.5 сая ₮

Анхны төсөвт өртөг 1,871.7 сая төгрөг байсныг 2026 онд 2,455.5 сая төгрөг болгож 583.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Газрын зөвшөөрөл олгогдоогүй, техникийн нөхцөлүүд авагдаагүй атал зураг төсөвт 2024.05.09-ний өдрийн 608/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлт гарсан нь төслийн үндсэн зөвшөөрөл, нөхцөлүүд бүрдээгүй байхад зураг төслийн шатны ажиллагаа хийгдсэн байгааг харуулж байна.

3.2.7. Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил — 4,040.2 сая ₮

Зураг төсөв 2023.09.29-нд батлагдсан, дулааны техникийн нөхцөлийг 2024.05.28-нд авч, ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2025.05.12-нд авсан бөгөөд магадлалын ерөнхий дүгнэлт гарсан байна. Гэвч цахилгаан, ус хангамжийн техникийн нөхцөлүүд авагдаагүй буюу инженерийн шугам сүлжээний нөхцөл бүрэн шийдвэрлэгдээгүй нь төслийн хэрэгжилтийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мөн уг төсөл нь Монгол Улсын 2026 оны төсөвт тусгагдаагүй байна.

3.2.8. Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/ — 4,939.5 сая ₮

Анхны төсөвт өртөг 5,000.0 сая төгрөг байсныг 2026 онд 4,939.5 сая төгрөг болгож 60.5 сая төгрөгөөр бууруулсан байна. Зураг төсөл 2024.09.24-нд батлагдсан, 7 суманд хэрэгжүүлэхээр газрын гэрчилгээ авсан, цахилгааны техникийн нөхцөлийг 2022.09.01, 2024.04.13, 2024.06.21, 2024.06.28-ны өдрүүдэд авсан боловч бусад техникийн нөхцөлүүд бүрдээгүй, ажил эхлүүлэх зөвшөөрлийн хүсэлт шатандаа байна.

3.3. Гэрээ байгуулалт, гүйцэтгэлийн баталгаа

Тендер шалгаруулалтын үр дүн гарч, гэрээ байгуулсан 6 төсөл, арга хэмжээний гэрээний үнийн дүн, гүйцэтгэлийн баталгаа болон хэрэгжилтийн явцыг шалгахад дараах байдалтай байна:

Хүснэгт 3. Гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний нэгдсэн мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэгч	Гэрээний үнэ (сая ₮)	Гүйцэтгэлийн баталгаа (сая ₮)	Биелэлт (%)
1	Загас үржүүлгийн төв /Сэлэнгэ/	Хидро-Инженеринг ХХК	1,173.6	35.2 (Голомт банк)	Эхлээгүй
2	Аймгийн төвийн авто зам 6.3 км /Сүхбаатар сум/	Жинчингранд ХХК	9,444.3	85.0 (ХХБ)	58.07
3	Сумын төвийн авто зам 10.3 км /Мандал сум/	Жинчингранд ХХК	10,004.6	90.1 (ХХБ)	59.71
4	Спорт заалны барилга /Жавхлант сум/	Сант-Өндөр ХХК	2,340.7	14.9 (Амар даатгал)	Эхлээгүй
5	Дулааны станц 1 дүгээр хэлхээ	МЭЗ ХХК	3,986.7	30.1 (Голомт банк)	Хугацаа болоогүй
6	ХАА-н үйлдвэржилтийн агропарк	Интерконсалтинг Констракшн ХХК	4,939.5	84.7 (Хас банк)	40.04

Гүйцэтгэлийн баталгааны үнийн дүнг шалгахад зарим төсөл, арга хэмжээний хувьд тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувиар тооцох гүйцэтгэлийн баталгаатай харьцуулахад дутуу гарсан байна. Тухайлбал, Аймгийн төвийн авто замын хувьд тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувиар тооцоход 118.8 сая ₮ байх ёстой ч 85.0 сая ₮-ийн баталгаа гаргуулсан, Сумын төвийн авто замын хувьд 120.9 сая ₮-ийн баталгааг гаргах ёстой атал оронд 90.1 сая ₮-ийн баталгаа гаргуулсан байна. Энэ нь ТБОНХБАҮХАТХ-ийн гүйцэтгэлийн баталгааны хэмжээний шаардлагыг хангаагүй байж болзошгүй болохыг харуулж байна.

3.4. Худалдан авах ажиллагаанд гарсан хэмнэлт

Гэрээ байгуулагдсан 6 төсөл, арга хэмжээний батлагдсан төсөвт өртөг болон гэрээний үнийн дүнг харьцуулан шалгахад нийт 242.8 сая орчим төгрөгийн хэмнэлт гарсан байна. Хамгийн их хэмнэлт Спорт заалны барилга /Жавхлант сум/ дээр 114.8 сая төгрөг, Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил 53.5 сая төгрөг, Сумын төвийн авто зам дээр 74.3 мянган төгрөг, Загас үржүүлгийн төв дээр 0.2 сая төгрөг тус тус гарсан байна.

3.5. Тендерийн зохион байгуулалт, баримт бичгийн бүрдэл

Аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалтын аргыг Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний жагсаалт"-ыг үндэслэн зөв сонгосон байна. Үнэлгээний хороог ТБОНХБАҮХАТХ, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолыг үндэслэн хууль зүйн дагуу байгуулсан байна.

Тендерийн баримт бичгийн бүрдлийг шалгахад Иргэдэд үйлчлэх мэдээллийн төв болон Загас үржүүлгийн төвийн хувьд батлагдсан иж бүрэн зураг төсөл, мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр боловсруулсан өртгийн төсвийн бүрдэл хангагдаагүй, бусад 6 төслийн хувьд баримт бичгийн бүрдэл бүрэн байна.

Гомдол, маргааны хувьд аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээнүүдэд тендер шалгаруулалттай холбоотой гомдол, маргаан гараагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хийсэн явцын дотоод аудитаар дараах нэгдсэн дүгнэлтийг гаргалаа:

Нэг. УТХО-аар 2026 онд хэрэгжүүлэх эрх шилжиж ирсэн 8 төсөл, арга хэмжээ нь **Барилгын тухай хууль** болон **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд (ТБОНХБАҮХАТХ)** заасан шаардлагуудыг бүрэн хангаагүй, зураг төсөл, техникийн нөхцөл, газрын зөвшөөрөл, магадлалын дүгнэлт, ажил эхлүүлэх зөвшөөрөл зэрэг үндсэн баримт бичиг, зөвшөөрөл бүрдээгүй нөхцөлд төсөвт тусгуулах, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, тендер зарлах **зөрчил нийтлэг илэрсэн байна.**

Хоёр. Загас үржүүлгийн төв, Сургуулийн спорт заалны барилга /Сайхан сум/, Спорт заалны барилга /Жавхлант сум/, Дулааны станцын хэлхээний ажил зэрэг **4 төсөл арга хэмжээ нь газрын зөвшөөрөлгүй**, техникийн нөхцөлүүд бүрэн авагдаагүй, ажил эхлүүлэх зөвшөөрөлгүй байхад төсөвт тусгагдаж, худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөн нь Барилгын тухай хуулийн 4.1.8-д заасан техникийн нөхцөлийн шаардлагыг хангаагүй байна.

Гурав. Загас үржүүлгийн төв нь **зөвхөн "техникийн тодорхойлолт"-ын түвшинд** боловсруулагдсан иж бүрэн зураг төсөл, мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийгдсэн өртгийн төсөвгүйгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төслийн иж бүрдлийн шаардлагад нийцээгүй байна.

Дөрөв. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Түшиг сум/, Загас үржүүлгийн төв зэрэг төсөл, арга хэмжээний **батлагдсан иж бүрэн зураг төсөл, мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр боловсруулсан өртгийн төсөвгүйгээр тендер зарласан** нь Барилгын тухай хуулийн 24.2-т заасан төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэх шаардлагыг хангаагүй бөгөөд худалдан авах ажиллагааг хуульд нийцээгүй нөхцөлөөр зохион байгуулсан байна.

Тав. Аудитад хамрагдсан **8 төсөл, арга хэмжээний бүгдэд** нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер зарлаагүй, түүний дотор Иргэдэд үйлчлэх мэдээллийн төв, Аймгийн төвийн авто зам, ХАА-н агропарк зэрэг 3 төсөл, арга хэмжээний тендерийг 2-3 удаа давтан зарласан байгаа нь ТБОНХБАҮХАТХ-ийн 44.4-т заасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд нь баталгаажуулж хэрэгжүүлэх шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Зургаа. Зарим төсөл, арга хэмжээний хувьд **гүйцэтгэлийн баталгааны хэмжээ** нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувиар тооцох ёстой хэмжээнээс бага байгаа нь гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавихад эрсдэлтэй байж болзошгүй байна.

Долоо. Анхны төсөвт өртөгтэй харьцуулахад Иргэдэд үйлчлэх мэдээллийн төв 4,582.8 сая төгрөг, Сургуулийн спорт заалны барилга 590.7 сая төгрөг, Спорт заалны барилга /Жавхлант сум/ 583.8 сая төгрөгөөр **төсөвт өртөг тус тус нэмэгдсэн** нь зураг төсөл, техникийн нөхцөл бүрдээгүй байхад анхдагч төсвийн тооцоолол хийгдсэн нөхцөл байдлыг харуулж байна.

ТАВ. АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгах, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон Захиалагчийн чиг үүрэг бүхий байгууллагуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

Зөвлөмж 1. Зураг төсөл, техникийн нөхцөлийн бүрдлийг хангах талаар

1.1. Загас үржүүлгийн төв, Сургуулийн спорт заалны барилга /Сайхан сум, Номгон тосгон/, Спорт заалны барилга /Жавхлант сум/, Дулааны станцын хэлхээний ажил зэрэг газрын зөвшөөрөлгүй, техникийн нөхцөл бүрдээгүй төслүүдийн хувьд тендер шалгаруулалтын дараагийн шатанд орохын өмнө газрын зөвшөөрөл, цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, холбоо дохиоллын техникийн нөхцөлүүдийг бүрэн авч баримтжуулах.

1.2. Загас үржүүлгийн төвийн "техникийн тодорхойлолт"-ыг батлагдсан иж бүрэн зураг төсөл болгон боловсруулж, Барилгын тухай хуулийн 4.1.30 дугаар зүйлийн дагуу магадлалын дүгнэлтийг авах.

1.3. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Түшиг сум/-ын тэнцвэрт төсвийг мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр Барилгын тухай хуулийн 24.2 дугаар зүйлд заасны дагуу боловсруулж баталгаажуулах.

Зөвлөмж 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах талаар

2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил (зураг төсөл, техникийн нөхцөл, газрын зөвшөөрөл, магадлалын дүгнэлт)-ын бодит хугацааг үндэслэн бодитой төлөвлөх, ингэснээр төлөвлөсөн хугацаанд тендер зарлах боломжийг бүрдүүлэх.

2.2. Тендерийг 2 болон түүнээс олон удаа давтан зарласан Иргэдэд үйлчлэх мэдээллийн төв, Аймгийн төвийн авто зам, ХАА-н агропарк зэрэг төслүүдийн хувьд давтан зарлах болсон шалтгааныг тодорхойлж, цаашид давтагдахгүй байх арга хэмжээ авах.

2.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаандаа хэрэгжүүлэх, төлөвлөсөн арга хэмжээний явцын тайланг улирал тутамд гаргаж Захирагчийн зөвлөлд танилцуулах.

Зөвлөмж 3. Гэрээний баталгаа, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих талаар

3.1. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувиар бүрэн тооцон гаргуулах. Аймгийн төвийн авто зам, Сумын төвийн авто зам зэрэг төслүүдийн гүйцэтгэлийн баталгаа дутуу гаргуулсан асуудлыг хянан зөв хэмжээнд хүргэх арга хэмжээ авах.

3.2. Гэрээний хэрэгжилтийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (publicinvestment.gov.mn)-д тогтмол шинэчилж бүртгэх, гүйцэтгэлийн явцын талаар сар тутамд тайлан гаргах.

3.3. Хугацаа хэтэрсэн, гүйцэтгэл удааширсан гэрээний хувьд гүйцэтгэгчид хууль зүйн дагуу алданги, торгууль ногдуулах, шаардлагатай тохиолдолд гэрээг хүчингүй болгох арга хэмжээг авах.

Зөвлөмж 4. Цаашид анхаарах асуудал

4.1. Дулааны станцын хамааралгүй схем 1 дүгээр хэлхээний ажил нь Монгол Улсын 2026 оны төсөвт тусгагдаагүй боловч ХБОСС-ын 2025 оны 25 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар эрх шилжиж ирсэн нь төсвийн уялдааг хангах эрх зүйн үндэслэлийг нягтлан шалгах шаардлагатай.


4.2. Дараа жилийн (2027 оны) худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа зураг төсөл, техникийн нөхцөлийн бэлэн байдал бүрдсэн төсөл, арга хэмжээг л төлөвлөгөөнд тусгахаар Захиалагчтай хамтран ажиллах.

4.3. Аудитаар илэрсэн зөрчил, дутагдалд авч хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор бичгээр хариу ирүүлэх.

Хянасан:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга  Т.Одсүрэн


Аудитын тайланг боловсруулсан:

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч (багийн ахлагч)  Т.Мөнхзул

Дотоод аудитор  Г.Дорждэрэм

Дотоод аудитор  Д.Ванчигмаа

Танилцсан:

Худалдан авах ажиллагааны газрын дарга  Д.Октябрь